



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот


Олон улсын инженерийн сургууль байгуулахыг дэмжих тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн “Олон улсын инженерийн сургууль байгуулах бэлтгэл хангах тухай” 284 дүгээр тогтоол, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 3.3 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургууль болон БНХАУ-ын Өвөр Монголын Аж үйлдвэрийн их сургууль хамтран “Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэргэд Олон улсын инженерийн сургууль” байгуулах тухай 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан гэрээ, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургууль болон БНХАУ-ын Өвөр Монголын Аж үйлдвэрийн их сургууль хамтран Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн салбар Олон улсын инженерийн сургууль байгуулахыг дэмжсүгэй.

2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн салбар Олон улсын инженерийн сургууль байгуулах хүсэлтийг Боловсролын яаманд уламжлахыг тус их сургуулийн Ректор (Т.Намнан)-д даалгасугай.

ДАРГА



Д.ГАНТУЛГА

367010019